



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 4/712

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Мянгад сумын Соёлын өдрийг тохиолдуулан ардын болон сонгодог урлагийг орон нутгийн иргэдэд хүргэх, олон угсаатны өв, соёлыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн авьяас чадвараа дайчлан ажиллаж буй Мянгад сумын Соёлын төвийн эрхлэгч Ж.Баярмаа, Цэцэрлэгийн туслах багш Л.Дарьсүрэн нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Ж.Баярмаа, Л.Дарьсүрэн нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Мянгад сумын Соёлын төвийн нягтлан бодогч, Цэцэрлэгийн эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖКАВ



№ 03456 Ch